



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

**11**  
АНГИ

# НИЙГЭМ СУДЛАЛ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....

### САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Сонгох даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

Тохиолдлыг уншаад 1-2 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Судлаач Бат нь улс орнуудын давхраажилтын уламжлалт хэв маягийн тухай судалгаа хийгээд 3 жил болсон. Давхраажилтын уламжлалт хэв маягийн тухай судалгаагаа анх Балба улсаа эхэлсэн. Тэрээр тухайн улсын хувьд гэрлэх ёс, байр суурийн өөрчлөлт, улс төрийн үйл ажиллагаанд оролцох боломж нөхцөл гээд маш олон чиглэлүүд дээр ажиллаж байсан. Дараа нь Пакистан улсын давхраажилтын уламжлалт хэв маягуудыг судалж харьцуулсан дүгнэлт гаргасан.

1. Судлаач Бат ямар зорилгоор улс орнуудын давхраажилтын уламжлалт хэв маягийн тухай судалгаа хийсэн бэ?
  - A. Европын улс орнуудад Балба, Пакистан зэрэг улсууд нь хамаардаг тул кастын давхраажилтын хэв маягийг судлах зорилгоор
  - B. Өмнөд Америкийн улс орнуудад Балба, Пакистан зэрэг улсууд нь хамаардаг тул кастын давхраажилтын хэв маягийг судлах зорилгоор
  - C. Азийн улс орнуудад Балба, Пакистан зэрэг улсууд нь хамаардаг тул кастын давхраажилтын хэв маягийг судлах зорилгоор
  - D. Хойд Америкийн улс орнуудад Балба, Пакистан зэрэг улсууд нь хамаардаг тул кастын давхраажилтын хэв маягийг судлах зорилгоор
2. Балба болон Пакистан улсын гэрлэлтийн хэлбэр ямар байсан бэ?
  - A. Гэрлэлтийн тодорхой бүлгийн дотоодод баталгаажуулдаг ёс.
  - B. Гэрлэлтийг тодорхой бүлгээс үл хамааруулан зохицуулах ёс.
  - C. Цус ойртохыг хатуу хориглодог ч тодорхой бүлгээс үл хамааруулан зохицуулах ёс.
  - D. Цус ойртохыг цээрлэдэггүй боловч тодорхой бүлгийн дотоодод баталгаажуулдаг ёс.
3. Дараах хүснэгтээс нэлэнхүй судалгааны тодорхойлолт болон жишээг олно уу.

Хүснэгт-а		Хүснэгт-б	
1	УБ хотын бүх өрхийг хамруулах ба хүн ам, орон сууцны тооллого явуулах судалгаа	1	Хувьсагчийг хэмжих, шинжлэх хувь хүн, бүлэг, байгууллага зэргийг хэлнэ.
2	УБ хотын бүх өрхийг хэмжих, шинжлэх хувь хүн, бүлэг, байгууллага зэргийг хэлнэ.	2	Эх олонлогийг бүхэлд нь хамруулах судалгаа.
3	Нийслэлийн өрхийг судлах бол УБ хотын бүх өрх хамаарна.	3	Судалгаа чиглэж бүх нэгжүүдийг хэлнэ.

A. a-1, b-2

B. a-2, b-2

C. a-3, b-1

D. a-2, b-1

4. Юань улсаас хойш “харлигууд” буюу харьяат иргэд дотооддоо дараах гурван хэсэгт хуваагддаг үүнийг тохирох өгөгдөлтэй тохируулна уу.

a) Сайн b) Дунд c) Адаг	1	Чинээлэг хөрөнгөтэй, элч, хиа зэрэг эрх мэдэлтнүүд
	2	Харц язгууртны түшмэд, дархад, тайж нарын хүргэн-тавнан гэх мэт
	3	Хар хүн хэмээх жирийн харц иргэд
	4	Ноёд, тайж, лам нар
	5	Гэрийн боолчууд

A. a2, b1, c3      B. a1, b4, c3      C. a2, b4, c5      D. a4, b2, c5

5. 1930, 1940-өөд оны үед манай улс уламжлалт шашин, соёл, үндэсний бичиг зэргээ орхисон үйл явдал нь дараах ойлголтуудын алинд нь хамаарах вэ?

A. Соёлын универсал      C. Соёлын түгээмэл шинж  
B. Соёлын солилцоо      D. Соёлын тулгалт

Тохиолдлыг уншаад 6-7 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Сэтгүүлч Маралмаагийн “Соёлын эрх чөлөө”-ний тухай сэдэвтэй нийтлэл нь 2022 онд хамгийн олон уншигчтай бичвэрээр тодорчээ. Энэхүү нийтлэл нь хамгийн олон уншигчтай болсон шалтгаан нь угсаатны ялгаатай бүлгүүд болон нутгийн уугуул иргэдийн соёлыг оролцуулан бүх соёлыг ижил тэгш үнэлж, хүндэтгэх тухай тайлбарласан. Мөн хувь хүн болон бүлгийн аж төрөх хэв маягаа сонгох, нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох боломжийг хязгаарлаж, байгаа явдалд шүүмжлэлтэй хандаж олон талын тайлбар нотолгоо гаргасан.

Маралмаа нь энэхүү “Соёлын эрх чөлөө”-ний тухай нийтлэлээ илүү их хүнд хүргэхийн тулд дараах гурван чиглэлээр нийтлэл бичихээ төлөвлөсөн байна.

- Хэнд ч бусдыгаа захирах засаглах эрх гэж байхгүй. Эрх бол хүн бүрд хамаарах ёстой. Хуулийн зорилго нь хүний эрхийг устгах буюу хавчин хасах явдал биш, харин түүнийг хамгаалж өргөжүүлэх явдал
  - Бүх хүмүүс эх хэлээрээ ярьж, өөрийн шашныг шүтэж, өөрийн соёлыг бүтээн туурвих бололцоог эдлэх. Мөн баталгаат боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, бусад олон төрлийн нийгмийн баталгаагаар хангагдаж байх
  - Кибернетикийн хувьсгал, цөмийн зэвсэглэл гэх мэт хүний оюун ухаан, техникийн өндөр чадвар, соёлын жишиг нь нийгмийн зан чанарыг хүнлэг бус болгож байгаа гэсэн чиглэлээр нийтлэл бичихээ төлөвлөсөн.
6. Соёлын эрх чөлөөний суурь зарчмыг илэрхийлсэн хэсгийг олоорой.
- A. Мөн хувь хүн болон бүлгийн аж төрөх хэв маягаа сонгох, нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох боломжийг хязгаарлаж, байгаа явдалд шүүмжлэлтэй хандаж олон талын тайлбар нотолгоо гаргасан.
- B. Кибернетикийн хувьсгал, цөмийн зэвсэглэл гэх мэт хүний оюун ухаан, техникийн өндөр чадвар, соёлын жишиг нь нийгмийн зан чанарыг хүнлэг бус болгож байгаа гэсэн чиглэлээр нийтлэл бичихээ төлөвлөсөн.
- C. Энэхүү нийтлэл нь хамгийн олон уншигчтай болсон шалтгаан нь угсаатны ялгаатай бүлгүүд болон нутгийн уугуул иргэдийн соёлыг оролцуулан бүх соёлыг ижил тэгш үнэлж, хүндэтгэх тухай тайлбарласан.
- D. Хэнд ч бусдыгаа захирах засаглах эрх гэж байхгүй. Эрх бол хүн бүрд хамаарах ёстой. Хуулийн зорилго нь хүний эрхийг устгах буюу хавчин хасах явдал биш, харин түүнийг хамгаалж өргөжүүлэх явдал

7. Э.Фроммын эрх чөлөөний тухай үзэл баримтлалыг илэрхийлж буй хэсгийг олоорой.
- Хэнд ч бусдыгаа захирах засаглах эрх гэж байхгүй. Эрх бол хүн бүрд хамаарах ёстой. Хуулийн зорилго нь хүний эрхийг устгах буюу хавчин хасах явдал биш, харин түүнийг хамгаалж өргөжүүлэх явдал
  - Бүх хүмүүс эх хэлээрээ ярьж, өөрийн шашныг шүтэж, өөрийн соёлыг бүтээн туурвих бололцоог эдлэх. Мөн баталгаат боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, бусад олон төрлийн нийгмийн баталгаагаар хангагдаж байх
  - Кибернетикийн хувьсгал, цөмийн зэвсэглэл гэх мэт хүний оюун ухаан, техникийн өндөр чадвар, соёлын жишиг нь нийгмийн зан чанарыг хүнлэг бус болгож байгаа гэсэн чиглэлээр нийтлэл бичихээ төлөвлөсөн.
  - Энэхүү нийтлэл нь хамгийн олон уншигчтай болсон шалтгаан нь угсаатны ялгаатай бүлгүүд болон нутгийн уугуул иргэдийн соёлыг оролцуулан бүх соёлыг ижил тэгш үнэлж, хүндэтгэх тухай тайлбарласан.
8. Дараах ойлголтуудын аль нь соёлын харилцан үйлчлэлийн хэлбэр вэ?
- Соёлын тулгалт, соёлын универсал, соёлын солилцоо
  - Соёлын солилцоо, Соёлын тулгалт, Соёлыг хуулбарлан дуурайх
  - Соёлын нийтлэг шинж, Соёлын эрх чөлөө, Соёлыг хуулбарлан дуурайх
  - Соёлын универсал, соёлын тулгалт, соёлыг хуулбарлан дуурайх

Хүснэгтийг ажиглаад 9-10 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Монгол улсын гадаад худалдаа, сая ам.долл.				
№	Үзүүлэлт	2021	2022	2023
1	Нийт экспорт	4896.5	4952.9	5842.8
2	Нийт импорт	4547.3	5599.3	4998.7
3	Гадаад худалдааны тэнцэл	?	?	?
4	Ашиг/ алдагдал	?	?	?

9. Дээрх гурван оны гадаад худалдааны тэнцлийг зөв тодорхойлоорой.
- 2021 онд /+349.2/, 2022 онд /-646.4/, 2023 онд /+844.1/
  - 2021 онд /-349.2/, 2022 онд /+646.4/, 2023 онд /-844.1/
  - 2021 онд /-349.2/, 2022 онд /+297.2/, 2023 онд /-546.9/
  - 2021 онд /+349.2/, 2022 онд /-297.2/, 2023 онд /+546.9/
10. Дээрх гурван оны гадаад худалдааны ашиг болон алдагдлыг зөв тодорхойлоорой.
- 2021 онд /алдагдал/, 2022 онд /ашиг/, 2023 онд /ашиг/
  - 2021 онд /ашиг/, 2022 онд /ашиг/, 2023 онд /алдагдал/
  - 2021 онд /ашиг/, 2022 онд /алдагдал/, 2023 онд /ашиг/
  - 2021 онд /алдагдал/, 2022 онд /алдагдал/, 2023 онд /ашиг/
11. Аль нь валютын ревальваци гэсэн ойлголтыг илэрхийлж байна вэ?
- Төв банк өөрийн валютын нөөцөөс зардал гарган валютыг худалдан авна
  - Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ
  - Валютын тогтсон өртгийг төрөөс бууруулах
  - Төв банкнаас валютын арилжааны ханшийг өсгөх

12. Үндэсний валютын ханш буурахад ямар үзэгдэл бий болох вэ?
- Экспортын бараа илүү их өрсөлдөх чадвартай болж, харин эх орны хэрэглэгчдийн хувьд импортын бараа үнэтэй болно.
  - Дотоодын хэрэглэгчдийн хувьд импортын бараа хямдарч, экспортлогчид өөрийн бүтээгдэхүүнээ борлуулахад илүү хүндрэлтэй болно.
  - Импортын бараа илүү их өрсөлдөх чадвартай болж, харин эх орны хэрэглэгчдийн хувьд импортын бараа үнэтэй болно.
  - Дотоодын хэрэглэгчдийн хувьд импортын бараа үнэд орж, экспортлогчид өөрийн бүтээгдэхүүнээ борлуулахад илүү хүндрэлтэй болно.
13. Гэм хорын ангилал аль нь вэ?
- Гэмт хэрэг, гэм буруу
  - Хохирол, хор уршиг
  - Гэм хор, гэм буруу
  - Ил, далд
14. Давж заалдах гомдол гаргасан хэргийг давж заалдах шатны шүүх хүлээн авснаас хойш хэд хоногийн дотор хянан шийдвэрлэх вэ?
- 7 хоног
  - 14 хоног
  - 21 хоног
  - 30 хоног
15. Гомдол хүлээж авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, хэргийн оролцогчдын гомдлыг хавсарган гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш орон нутагт хэд хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлэх вэ?
- 3 хоног
  - 5 хоног
  - 7 хоног
  - 14 хоног
16. Дараах зүйлсийн аль нь УИХ-ын үйл ажиллагаа вэ?
- Хүний эрхийг зөрчсөн тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх
  - Хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээний биелэлтийг хангах, үр дүнг УИХ, НҮБ-д тогтмол тайлагнах
  - Хууль тогтоох замаар хүний эрхийг хангах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх, засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг
  - Хууль тогтоох замаар хүний эрхийг хангах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээний биелэлтийг хангах
17. Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

a) Тунхаглал b) Конвенц, пакт c) Протокол	1	Өөрт болон бусдад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт
	2	Хуульчлан дагаж мөрдөх албагүй зөвлөмж, уриалгын шинжтэй баримт бичиг
	3	Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан баримт бичиг
	4	Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр
	5	Хоёр болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ

- a2, b5, c3
- a2, b3, c5
- a1, b3, c5
- a1, b3, c4

18. Хэм хэмжээ - Зохицуулалтын дэд системийн үүрэг аль нь вэ?

- A. Улс төрийн системийн бүрдэл хооронд холбоо тогтоох, төр болон улс төрийн институтэд мэдээлэл дамжуулах/сувгийн/ үүрэг гүйцэтгэнэ.
- B. Улс төрийн амьдрал дахь хүмүүсийн үйл байдал болон бусад объектив үүргийг тодорхойлох үүрэг гүйцэтгэнэ.
- C. Улс төрийн системийн үйлчлэл нь хүмүүсийн авч буй мэдээллийн түвшин, ихэд шалтгаалдаг болохыг илэрхийлэх үүрэг гүйцэтгэнэ.
- D. Төрийн зүгээс үзэл бодол тулгах маш том механизм үйлчилж, хүнийг хариуцлагагүй, идэвхгүй байр сууринд аваачих тал байдгийг илэрхийлэх үүрэг гүйцэтгэнэ.

19. Дараах тодорхойлолтуудаас Д.Истоны улс төрийн системийн оролтод хамаарах шаардлага аль вэ?

- A. Аль нэг нам, нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх, тодорхой бодлого, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх зэрэг орно.
- B. Улс төрийн системийн дотроос эсвэл, түүнийг хүрээлэн байгаа экологийн, эдийн засгийн, соёлын зэрэг янз бүрийн системүүдээс гарч буй тулгалтууд
- C. Татвар төлөх, төрийн болон цэргийн алба хаших, хууль журмыг дагаж мөрдөх, төрийн албан ёсны мэдээлэл, бэлгэдлийг хүндэтгэн үзэх зэрэг орно.
- D. Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл сурталчилгаа зэрэг болно.

20. Сонгуульд санал өгөх үйл явцыг зөв дараалалд оруулна уу.

Өгөгдөл: /**a**-Саналын хуудас авна, **b**-Саналаа өгнө, **c**-Иргэний үнэмлэхээ авч сонгуулийн байранд ирнэ **d**-Үнэмлэхийг сонгуулийн нэрийн жагсаалттай харьцуулна, **e**-Сонгуулийн хайрцагт саналаа хийнэ/



- A. 1c,2d,3a,4b,5e
- B. 1c,2a,3b,4d,5e
- C. 1d,2c,3a,4b,5e
- D. 1d,2c,3b,4a,5e

21. Дараах хүснэгтэд өгөгдлүүдийг зөв байршуулна уу.

Өгөгдөл: /1-Глобал түвшин; 2-ЕХ, ШХАБ, АПЕК, АСЕАН; 3-НАТО, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн/

Олон улсын байгууллага	
↓	
Үйл ажиллагааны цар хүрээгээр	
↓ ↓	
a.....	Бүс нутгийн түвшин
b.....	c.....

- A. a2,b3,c1
- B. a2,b1,c3
- C. a1,b3,c2
- D. a1,b2,c3

22. Монгол улсын гадаад бодлогын 6 тулгуур чиглэлд аль нь үл хамаарах вэ?

- A. Олон улс гүрэнтэй хамтран ажиллах, гадаад харилцааг олон хэлбэрээр явуулах
- B. Азийн бүс нутгийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох
- C. Өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх
- D. Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх

23. Неомарксист онол нь олон улсын харилцааны тоглогчийг юу гэж үздэг вэ?

- A. Бүрэн эрхт улс, тэдгээрийн холбоо, эвсэл байна гэж үздэг.
- B. Нийгмийн тодорхой анги бүлэглэлүүдийн харилцааны үр дүн гэж үздэг.
- C. Бүрэн эрхт улс, засгийн газрын бус байгууллагууд байдаг гэж үздэг.
- D. Үндэстэн дамнасан корпорацууд, хувь хүмүүс байдаг гэж үздэг.

### САНАМЖ

- Хоёрдугаар хэсгийн даалгаврыг (2.1; 2.2) гүйцэтгэхдээ хариултын хуудас дахь САНАМЖ хэсэгт байгаа зааврын дагуу хариултыг будаарай.

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1 Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу.

a) Сонирхлын бүлэг b) Аномик c) Эвсэл холбооны d) Эвсэл холбооны бус e) Байгууллагдажсан	1	Зохион байгуулалтгүй боловч хүмүүс голдуу яс үндэс, угсаа гарал зэрэг нийтлэгээрээ хамтрагддаг
	2	Бүлгийн гишүүдийн сонирхлыг нэг үзүүрт чиглүүлэх буюу нэгтгэх үйл явц
	3	Өөрийн гэсэн тодорхой зорилго, чиглэлд үндэслэгдсэн зохион байгуулалттай бүлэг
	4	Ашиг сонирхлоо хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагуудад нөлөө үзүүлэх
	5	Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт, бослого, үймээн
	6	Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг шууд удирдлага дор зохион байгуулалттай үүсгэн байгуулагддаг.
	7	Хувийн эрх ашгийн төлөө бус, бүлгийн буюу нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх зорилгоор иргэдээс сайн дураар үүсгэн байгуулсан байгууллага, хөдөлгөөн юм.

2.2 Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

a) НҮБ b) ЕХ c) ШХАБ d) АПЕК e) АСЕАН	1	1957 онд Ромын гэрээгээр байгуулсан
	2	1667 онд Индонез, Тайланд, Сингапур, малайз, Филиппиний Гадаад хэргийн сайд нарын хурлаар үндэслэн байгуулсан.
	3	Ази-Европын уулзалт
	4	Анх ОХУ, Хятад, Казакстан, Күргизстан, Тажикстаны хоорондын хилийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор үүссэн.
	5	Ази, Номхон далайн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны чуулга
	6	1946 онд байгуулагдсан Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага.
	7	Хүний үндсэн эрх, хувь хүний нэр төрд итгэх итгэлийг дахин батлах гэсэн үндсэн зорилготой байгуулсан.